



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
АЖЛЫН ТАЙЛАН**

2022.12.28

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар батлагдсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус үндэслэл болгов.

Хоёр. Танилцуулга:

ЗТХЯ-ЫН 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 134 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 52 арга хэмжээ, 90 хувийн 44, 70 хувийн 18, 50 хувийн 5, 30 хувийн 10, хугацаа болоогүй буюу үнэлгээнд тооцоогүй 5 арга хэмжээний хэрэгжилт **85.04** хувь байна. Үүнээс хариуцсан нэгж, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээр нь авч үзвэл:

/Хүснэгт 1/

№	Нэгж	Нийт	Үнэлгээ /хувиар/							ХШҮ
			100	90	70	50	30	0	ХБ	
1	БТГ	27	13	6	5	1	2	-	-	85.2
2	ТЗУГ	14	7	4	2	-	-	-	1	92.3
3	АЗБХЗГ	39	20	10	3	-	4	-	2	87.3
4	ИНБХЗГ	13	2	4	4	1	1	-	1	76.7
5	АТБХЗГ	10	3	2	2	3	-	-	-	77.0
6	ТЗДТБХЗГ	19	3	10	2	-	3	-	1	79.4
7	ХШУДАГ	12	4	8	-	-	-	-	-	93.3
Нийт		134	52	44	18	5	10	-	5	85.04

Яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болсон 3, санхүүжилт хасагдаж, зорилтод түвшинд хүрэх боломжгүй болсон 2 арга хэмжээг нийт үнэлгээнд оруулж тооцоогүй. Эдгээрийг дурдвал:



1.5.1. "Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хүчилттай авто зам барилгын ажлыг эхлүүлнэ" /АЗБХЗГ, 1-4 улирал/;

Биелэлт: Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хүчилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр зарлаж 04 дүгээр сарын 13-ны өдөр нээсэн. Тендерт 1 хуулийн этгээд саналаа ирүүлсэн боловч тендерийн баримт бичигт заагдсан нөхцөл хангагүйн улмаас тендер хүчингүй болсон.

ТХААГ-аас тендерийг дахин 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зарласан. 2022 онд 20.8 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч тодотголоор хасагдаж, 2.5 тэрбум төгрөг болсон. Тодотголоор санхүүжилт хасагдсан тул санхүүжилтээс шалтгаалан цаашид барилгын ажил хүрэх түвшиндээ хүрэх боломжгүй нөхцөл байдал үүссэн.

ТХААГ-аас тендерийг дахин 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр нээсэн боловч нэг ч хуулийн этгээдээс санал ирээгүй. Тендер хүчингүй болсон.

2022 оны батлагдсан төсөөт өртөгт магадлал хийлгэн 2023 оны МУ-ын улсын төсөөт тусгуулсан. Сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл ажил хангагдаж байна. /Санхүүжилт хасагдсан, тендер 3 удаа зарласан ч амжилтгүй болсон/

1.5.2. "Дорнод аймгийн Баян-Уул сумын Ульхан боомт хүртэлх 50 км хатуу хүчилттай авто зам барилгын ажлыг эхлүүлнэ" /АЗБХЗГ, 1-4 улирал/

Биелэлт: Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг бэлдэж, Захиалагчийн зөвшөөрлийн дагуу 2022.01.06-ны өдрөөс эхлэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 5 удаа зарласан боловч "Нэг ч оролцогч санал ирүүлээгүй", "Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй", "Тендер хүчинтэй хугацаанд багтаан гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй" зэрэг шалтгаанаар амжилтгүй болсон.

Уг ажлын зураг төслийг 2016 онд боловсруулсан ба шинэчлэгдсэн магадлалын дүгнэлтээр баталгаажсан төсөөт өртөг нь улсын төсвийн тухай хуульд тусгагдсан дунгээс ихээхэн зөрүүтэй байсан тул магадлалын дүгнэлтийг дахин шинэчилж, 2023 оны төсвийн тухай хуульд тусгуулсан.

2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан тендерийг дахин зарлахаар бэлтгэж байна. /5 удаа тендер зарлаж, амжилтгүй болсон. Захиалагчаас дахин зарлах зөвшөөрөл хүлээж байна./

1.13.2 "Орон нутгийн нисэх буудлын аэродромд их засвар хийнэ" /ИНБХЗГ, 1-4 улирал/

Биелэлт: Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д Ховд, Чойбалсан, Мөрөн, Хатгал, Дэглий цагаан, Хархорин, Хужирт нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг "шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр оруулах саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлт 2022.01.13-ны өдрийн 01/133 тоотоор ТХААГ-т, 2022.02.23-ны өдрийн 01/875 тоотоор ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. Мөн Засгийн Газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанд агаарын ачаа тээврийн өнөөгийн байдал, цаашид хөгжүүлэх боломж, хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар танилцуулж, орон нутгийн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх, түүнчлэн Дэглий цагаан, Өндөрхаан нисэх буудалд хилийн агаарын замын олон улсын боом байгуулах, нисэх буудлын ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авахыг холбогдох сайд нарт даалгасан болно. (Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэл).

ЗТХ-ийн сайдын 2021 оны А/189 дугаар тушаалаар "Дэлүүнболдог" нисэх буудлын барилгын ажлыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг ИНЕГ-т шилжүүлсэн. Мөн "Дэлүүнболдог" нисэх буудлын хөөрч буух шороон зурvas, агаарын хөлгийн зогсоолын засварын ажил хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202006

дугаартай тендерийг 2022.03.04-ны өдөр зарласан, 2022.04.18-ний өдөр нээсэн ч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хүчингүй болгосон.

Ховдын Булган сумын нисэх буудлын их засвар: Нисэх буудлын аэродромын их засварын ажлын санхүүжилт төсвийн хэмнэлтийн горимын улмаас 2022 оны төсөвт суугаагүй тул уг ажлыг энэ онд гүйцэтгэх боломжгүй.

Хэнтийн Дадал сумын Дэлүүн болдог нисэх буудлын их засвар:

ЗТХ-ийн сайд, Сангийн сайдын 2022.01.21-ний А/17/16 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан ИНҮТ-ийн өөрийн орлогоос санхүүжих 2022 оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад “Дэлүүн болдог” нисэх буудлын хөөрч буух шороон зурvas, агаарын хөлгийн зогсоолын засварын ажилд 422,7 сая төгрөгийн санхүүжилт тусгасан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202006 дугаар тендерийг 2022.03.04-ний өдөр зарласан, 2022.04.18-ний өдөр нээж гэрээ байгуулах эрх олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хүчингүй болсон.

3.5.4 “Усан замын тээврийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлнэ” /ТЗДТБХЗГ, 1-4 улирал/

Биелэлт: “1. Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2021 оны А/173 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Хөвсгөл нуурын эрэгт усан замын вокзал байгуулах төсөл”-ийн уралдаант шалгаруулалтыг эхний удаа 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр зарлаж, 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр нээхэд аливаа нэгэн оролцогч санал ирүүлээгүй. Ажлын хэсэг хуралдаж уралдаант шалгаруулалтыг дахин зарлах дүгнэлт гаргасны дагуу 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим хуудас, өдөр тутмын Өнөөдөр сонини 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн №247(7295) дугаарт монгол, англи хэлээр нийтлүүлж зарлан 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр нээхэд төсөлд оролцох санал иргэн, хуулийн этгээдээс ирүүлээгүй. Иймээс ажлын хэсгийн зүгээс сонирхогч этгээд байгаа тохиолдолд Концессын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу шууд гэрээ байгуулах, эсхүл уралдаант шалгаруулалтыг дахин зарлах дүгнэлтийг гаргаж, зохих шийдвэр гаргуулахаар эрх бүхий этгээд /ТХААГ/-д санал хүргүүлсэн.

Концессын гэрээгээр хэрэгжүүлэх “Хөвсгөл нуурын эрэгт усан замын вокзал байгуулах төсөл”-ийн сонгон шалгаруулалтыг ТХААГ-аас 2 удаа зарласан ч амжилтгүй болж, сонирхогч этгээдтэй шууд гэрээ байгуулах нөхцөл үүссэн ч сонирхогч этгээд гарч ирээгүй. Иймд Зам, тээврийн салбарт концессоор хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмж тусгах болон хасуулахаар 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 03/2294 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд “Хөвсгөл нуурын эрэгт усан замын вокзал байгуулах төсөл”-ийг хасуулах саналыг хүргүүлсэн.

“Хөвсгөл нуурын эрэгт барих усан замын төв буудлын зураг төсөл боловсруулах” төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын төсвийн хөрөнгөөр Зам, тээврийн салбарт 2023 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XV.3.2.1-д тусгыулан 2022 оны 04 дүгээр сарын 11-ний 01/1582 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн БНСУ-ын КОЙКА-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт уг төслийг хамруулах саналыг англи хэл дээр бэлтгэж 2022 оны 04 дүгээр сарын 28-ны 03/1936 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

2. Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газартай үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна. Тус газраас “Туул голын эрэг дагуу амралт зугаалгын цогцолбор”-үүд барих бодлогынхоо хүрээнд Туул голын дагуу нийт 6-н байршилд 83,88 га талбайд 28,0 тэрбум төгрөг төсөвлөсөн. Туул голын эрэгт усан замын тээврийн хэрэгслийн зогсоол байгуулахаар тус яамны сонгосон газрыг Нийслэлийн ИТХ-ын тогтоолоор 10,5 га болгон өргөтгөж, усан замын тээврийн хэрэгслийн зогсоолыг дотроо агуулсан амралт зугаалгын цогцолборыг Туул гол дээр байгуулах шийдвэр гаргасан. Үүний дагуу амралт зугаалгын цогцолборын зураг төслийг Хот төлөвлөлтийн хүрээлэнгээс боловсруулан батлуулсан бөгөөд зураг төслийг үүнд 3,9 тэрбум төгрөгийн санхүүжилт, үүнээс зогсоолд 593 сая



төгрөгийн санхүүжилт шаардагдсан. Тус яамнаас усан замын тээврийн хэрэгслийн зогсоол барих ажлын санхүүжилтэд зориулж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/20 дугаар тушаалаар 250.0 сая төгрөгийг Нийслэлийн ЗДТГ-т шилжүүлсэн. Гэсэн ч улс орон хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбогдуулан энэхүү ажлын санхүүжилтийг 2023-2024 оны нийслэлийн төсөөт суулгахаар Нийслэлээс хойшлуулсан.

3. Усан замын тээврийн дэд бүтцийг барьж байгуулах зорилгоор Архангай аймгийн Өгий нуурт усан замын хяналт, зохицуулалтын байр барихаар Далайн захиргаанаас 190 сая төгрөг /өмнө нь 15 сая төг байсан/-ийн тендерийг зарлаж 2022 оны 05 дугаар сарын 30-нд тендерийн нээлт хийхэд ажил гүйцэтгэх санал аливаа нэгэн хуулийн этгээдээс ирүүлээгүй байна. Иймд уг тендерийг Сангийн яамтай зөвшилцөн 2022 оны 9 дүгээр сарын 05-ны өдөр дахин зарласан. Тендерийг 2022 оны 10 дугаар сарын 06-нд нээсэн ч амжилтгүй болсон.

4. Мөн хөвөлтийн улиралд усан замын тээврийн аюулгүй байдлыг хангах, хяналтыг сайжруулах бодлогын хүрээнд Өгий нуурт усан замын хяналтын катер худалдан авах 150 сая төгрөгийн тендерийг Далайн захиргаанаас зарлан 2022 оны 05 дугаар сарын 17-нд нээж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, бараа үйлчилгээ худалдан авах гэрээг шалгарсан Голден Хоул компанийтай байгуулсан. Эдгээр сонгон шалгаруулалт, худалдан авах ажиллагааны ажлын хэсэг, үнэлгээний хороог яамны зүгээс мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хяналт тавьж, хамтран ажилласан.

3.8.3 Зам, тээврийн салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөн зохион байгуулна /ТЗУГ, 1-2 дугаар улирал/

Биелэлт: Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор энэ арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон.

Төлөвлөгөөнд 30 хувийн хэрэгжилттэй 10 арга хэмжээ байна. Үүнд:

1.1.2 “Гашуунсухайт өртөөнөөс Улсын хилийн шугам хүртэлх 7.9 км төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлнэ” /ТЗДТБХЗГ, 1-4 улирал/

Биелэлт: Барилгын ажлын төлөвлөгөөг батлуулсан. ТЭЗҮ-ийг ШУТЗ-өөр 2022.03.15-ны өдөр хэлэлцүүлсэн. Боомтын төмөр замын хил нэвтрэх хэсгийн техникийн шийдлийг БНХАУ-ын төмөр замын байгууллагатай тохиролцсон. Хятадын Хөгжил шинэчлэлийн хороотой 2022.05.22-нд цахим уулзалт зохион байгуулж, Хятадын талаас Засгийн газрын шийдвэр хүлээж байгаа талаар мэдээгдсэн. Монгол-Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам барих тухай өрөнхий хэлэлцээр байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.08.03-ны өдрийн хуралдаанд танилцуулан, зөвшөөрөл гаргуулсны үндсэн дээр “Эрдэнэс тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Чайна энержи” компаниуд 2022.08.08-ны өдөр тус хэлэлцээрийг байгуулсан. Түүнчлэн Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэсний хөгжил шинэчлэлийн хороо хооронд “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын холболтын тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2022 оны 08 дугаар сарын 07-ны өдөр байгуулж, тус боомтын холболтын гол техникийн нөхцөл болох төмөр замын царигийн асуудлыг Хятадын талтай харилцан тохиролцсон. Эдгээр шийдвэрүүдийн дагуу хоёр талын төмөр замын байгууллагууд Гашуунсухайт-Ганцмод боомтуудыг 2014 онд батлагдсан “Гашуунсухайт төмөр замын ТЭЗҮ-г үндэслэл болгон холбоо тохиролцсон, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар батлуулсан. Мөн хилийн Гашуунсухайт боомтын төмөр замын барилгын ажлын санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын 2022.11.30-ны өдрийн хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлсэн. Гашуунсухайт боомтын хил холболтын төмөр замын ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар боловсруулсан. Батлуулахад бэлэн болсон.

1.1.6. “Хөөт-Чойбалсан чиглэлийн 192 км төмөр замын төслийг эхлүүлнэ” /ТЗДТБХЗГ, 1-4 улирал/



Биелэлт: Засгийн газрын 2022 оны 105 дугаар тогтоолоор Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулсан ба Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолоор Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК байгуулан Концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулах, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад, дотоодын хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх, сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг “Монголын төмөр зам” ТӨХК-д даалгасан бөгөөд хэрэгжилтийг ханганд ажиллаж байна. “Монголын төмөр зам” ТӨХК-аас Төслийн тусгай зориулалтын компанийд хөрөнгө оруулж хамтран ажиллах сонирхол бүхий этгээдийг сонгон шалгаруулахаар зар оруулсан 6 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд материал авч, тус чиглэлийн төмөр замын төсөлд 8 санал ирсэн. Дэд ажлын хэсгээс саналуудыг “Урьдчилсан сонгон шалгаруулалтын үнэлгээний баримт бичиг”-ийн Ерөнхий шаардлага, Санхүүгийн чадавхи, Техникийн чадавхийн бурдлийн дагуу материал хүлээн авсан цаг хугацааны дарааллаар нэгтгэсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж, тус чиглэлийн төмөр замын төсөлд 2 компанийтай хэлцэл хийхийг даалгасан. Үүний дагуу тус чиглэлийн төсөлд концессын гэрээний төсөл боловсруулж, “Ийст коридор рэйлрөүд” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-тай уулзалт хийж, эхний ээлжинд эдгээр компанийудаас хэрхэн хамтран ажиллах талаар саналуудыг бичгээр хүлээн авч дахин санал солилцохоор тохиролцсон. Зүүн чиглэлийн төсөлд “Ийст коридор рэйлрөүд” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-үүд сонгогдож, гэрээ байгуулах хэлэлцээр хийгдэж байна.

1.1.7. “Хөөт-Бичигт чиглэлийн 234.1 км төмөр замын төслийг эхлүүлнэ” /ТЗДТБХЗГ, 1-4 улирал/

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 105 дугаар тогтоолоор Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулсан ба Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолоор Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК байгуулан Концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулах, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад, дотоодын хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх, сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг “Монголын төмөр зам” ТӨХК-д даалгасан бөгөөд хэрэгжилтийг ханганд ажиллаж байна. “Монголын төмөр зам” ТӨХК-аас Төслийн тусгай зориулалтын компанийд хөрөнгө оруулж хамтран ажиллах сонирхол бүхий этгээдийг сонгон шалгаруулахаар зар оруулсан 6 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд материал авна. Тус чиглэлийн төмөр замын төсөлд 8 санал ирсэн. Дэд ажлын хэсгээс саналуудыг “Урьдчилсан сонгон шалгаруулалтын үнэлгээний баримт бичиг”-ийн Ерөнхий шаардлага, Санхүүгийн чадавхи, Техникийн чадавхийн бурдлийн дагуу материал хүлээн авсан цаг хугацааны дарааллаар нэгтгэсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж, тус чиглэлийн төмөр замын төсөлд 2 компанийтай хэлцэл хийхийг даалгасан. Үүний дагуу тус чиглэлийн төсөлд концессын гэрээний төсөл боловсруулж, “Ийст коридор рэйлрөүд” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-тай уулзалт хийж, эхний ээлжинд эдгээр компанийудаас хэрхэн хамтран ажиллах талаар саналуудыг бичгээр хүлээн авч дахин санал солилцохоор тохиролцсон. Үүний дагуу Зүүн чиглэлийн төсөлд “Ийст коридор рэйлрөүд” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-үүд сонгогдож, гэрээ байгуулах хэлэлцээр хийгдэж байна.

1.5.8 “Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км, хатуу хучилттай авто зам барих бэлтгэл ажлыг хангана.” /АЗБХЗГ, 1-4 улирал/;

Биелэлт: Засгийн газрын 2022.02.23-ны өдрийн хуралдаанд ШСБ-д тусгагдсан хилийн боомт чиглэлийн авто замын төслүүдийн явц болон цаашид авах арга хэмжээний талаар



санал боловсруулан танилцуулсан. Концесс, төр, хувийн хэвшилийн түншлэлийн асуудлыг ЭЗХЯ хариуцахаар болж, чиг үүрэг шилжсэн. Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан төслүүдийн явц байдлын талаар 2022.03.30-ны өдрийн ЗГ-ын хуралдаанд танилцуулсан. Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу “Баруун-Урт-Бичигт чиглэлийн авто зам төсөл”-ийн зардал, үр ашгийн тооцоог 2 хувилбараар боловсруулж, төвч танилцуулга, мэдээллийн хамт 2022.05.11-ний 03/2161 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.

Мөн тус төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтын баримт бичигт шаардлагатай авто замын үндсэн үзүүлэлтүүд, тавигдах шаардлагуудыг боловсруулж ТХААГ-т 2022.06.03-ны 03/2562 албан тоотоор хүргүүлсэн. Засгийн газрын 2022.05.04-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор Баруун-Урт-Бичигт чиглэлийн замын концесс олгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахыг ТХААГ-т даалгасан. ТХААГ-т ажлын хэсэг байгуулагдсан боловч өнөөдрийг хүртэл хуралдуулаагүй, уралдаант шалгаруулалтыг зарлаагүй байна.

1.6.6 “Багануур хотоос Төв аймгийн Мөнгөнморьт сум хүртэл 60 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг үргэлжлүүлнэ” /АЗБХЗГ, 1-4 улирал/;

Биелэлт: 2022 онд 6.4 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч тодотголоор хасагдаж, 3.8 тэрбум төгрөг тусгасан. Улсын төсөөт хөрөнгө багаар тусгагдаж байсан бөгөөд үлдэгдэл санхүүжилт 2023 оны төсөөт тусгасан. 2022 оны 3-р улирлын эхний байдлаар талбайд өөрийн шуудуу, сум доторх явган замын ажлууд хийгдсэн ба гүйцэтгэгч нь бараа материал, түүшиний үнэ батлагдсан төсвөөс 2-3 дахин өссөнөөс шалтгаалан ажил хийх боломжгүй нөхцөл үүсэж, алдагдалд орсон тул төсөөт дахин магадлал хийлгэх асуудлыг тавьсан бөгөөд шийдэгдэх хүртэл ажлыг 2022.08.03-ны өдрөөс түр зогсоох хүсэлтийг ируулсан. Тухайн асуудлын талаар ТНБД-тай холбогдох төлөвлөлүүдийг оролцуулан 2022.09.13-ны өдөр уулзалт зохион байгуулж, талбайд ажлыг эхлүүлэн, төлөвлөсөн хөрөнгийг ашиглах талаар гүйцэтгэгчид чиглэл өгсөн.

2022 оны 4 улиралд гүйцэтгэгч барилгын ажлыг огт хийж гүйцэтгээгүй, улсын төсөөт тусгасан хөрөнгийг ашиглаагүй, гэрээний үүргээ биелүүлэн ажиллаагүй тул 2022 оны гэрээ дүгнэх ажлын хэсгийн 2022.11.22-ны өдрийн хурлаар Захиалагчтай байгуулсан гэрээг цуцлах шийдвэрийг гаргасан. Гэрээ цуцлах ажлын хэсгийн тушаал эцэслэн гарсны дараа илүү санхүүжсэн асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргахаар төлөвлөж байна. БУА 76.8 хувьтай.

1.6.9 “Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 31.08 км зам авто замын барилгын ажлыг эхлүүлнэ” /АЗБХЗГ, 1-4 улирал/

Биелэлт: 2022 оны Улсын төсөөт 10.5 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч тодотголоор хасагдаж, 6.3 тэрбум төгрөг тусгагдсан. 2022 оны 1-р улиралд тус авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд ТХААГ нь тендерийг 2021.12.22-нд зарласан, 2022.02.10-нд нээсэн ч амжилтгүй болсон.

2022 оны 2-р улиралд ТХААГ-аас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, хамгийн сайн үнэлгээдсэн “Эйч Кей Би интернэйшил холдинг” ХХК-д гэрээ байгуулах мэдэгдэл өгсөн боловч Сангийн яаманд гомдол гарч, тендер хүчингүй болсон.

ТХААГ-аас дахин тендер зарлаж, гүйцэтгэгчээр “РЭС” ХХК шалгарч, 2022.08.09-нд гэрээ оройтож байгуулагдсанаар 3-р улирлын төлөвлөсөн хэмжээнд буюу зорилтот түвшинд хүрэх боломжгүй нөхцөл байдал үүсэж байна. Талбайд барилгын ажлын улаан шугам хүлээн авч, нүүлгэн шилжүүлэлт болон ажил эхлэх бэлтгэл ажлыг хангаж байна. БУА 1.5%. Хүрэх түвшин-5%, суурь түвшин- шинээр хэрэгжих авто зам.

1.6.10 “Ховд-Өлгий чиглэлийн авто замаас Эрдэнэбүрэн сум чиглэлийн 19.776 км авто замын барилгын ажлыг эхлүүлнэ” /АЗБХЗГ, 1-4 улирал/;



Биелэлт: Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн дахин зарлаж үнэлгээг хийж тайланг АХБ-нд зөвшөөрөл авахаар хүргүүлсний дагуу АХБ-аас гүйцэтгэгч "Түм дэлгэрэх" ХХК-д гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн. Гэвч гүйцэтгэгч байгууллага бараа материалын үнэ огцом өссөн тул тендерт орсон үнээр гэрээ байгуулах боломжгүй, үнэ нэмсэн тохиолдолд гэрээ байгуулах боломжтой тухай мэдэгдсэн.

1.13.1. "Орон нутгийн нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгэн хүчитгэн 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ" /ИНБХЗГ, 3-4 улирал/

Биелэлт: Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанаар орон нутгийн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр шийдвэрлүүлсэн (XIV тэмдэглэл).

Ховд, Мөрөн нисэх буудлыг Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-р 2022.05.19-ний өдөр олон улсын нисэх буудал гэж зарласан. Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг тус тус баталсан. (2022.09.12-ны №18, 19, 20, 21) Төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг БХБ-ын сайд (ТЭЗ)-ын төсвийн "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улсын хэмжээнд)" -т тусган санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр СЯ-нд хүргүүлсэн. (2022.10.04-ний 01/4549) Төслийг "зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концессоор хэрэгжүүлэх ажлын даалгаврын төсөл боловсруулж, бэлтгэл ажлыг хангуулахаар ИНЕГ-т хүргүүлсэн 2022.12.06-ны өдрийн /09/5622 тоот/.

Дэглий цагаан нисэх буудалд агаарын замын хилийн боомт байгуулах асуудлыг шийдвэрлүүлэхээр Сангийн сайд бөгөөд Хилийн боомтын үндэсний зөвлөлийн даргад хүргүүлсэн. /2022.02.25-ны 01/904 тоот/ Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орсноор боомтын асуудал эрхэлсэн сайд асуудлыг хариуцаа болсон. Жайка" ОУХАБ-аас хэрэгжүүлж буй "Монгол Улсын Хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Чойбалсан нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгон хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийн нисэхийн бус орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран судалгаа хийж байна.

1.13.2 "Орон нутгийн нисэх буудлын аэродромд их засвар хийнэ" /ИНБХЗГ, 1-4 улирал/

Биелэлт: Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д Ховд, Чойбалсан, Мөрөн, Хатгал, Дэглий цагаан, Хархорин, Хужирт нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг "шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр оруулах саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлциүүлэн шийдвэрлүүлэх хүсэлт 2022.01.13-ны өдрийн 01/133 тоотоор ТХААГ-т, 2022.02.23-ны өдрийн 01/875 тоотоор ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. Мөн Засгийн Газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанд агаарын ачаа тээверийн өнөөгийн байдал, цаашид хөгжүүлэх боломж, хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар танилцуулж, орон нутгийн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх, түүнчлэн Дэглий цагаан, Өндөрхаан нисэх буудалд хилийн агаарын замын олон улсын boom байгуулах, нисэх буудлын ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авахыг холбогдох сайд нарт даалгасан болно (Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэл).

ЗХ-ийн сайдын 2021 оны A/189 дугаар тушаалаар "Дэлүүнболдог" нисэх буудлын барилгын ажлыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг ИНЕГ-т шилжүүлсэн. Мөн "Дэлүүнболдог" нисэх буудлын хөөрч буух шороон зурвас, агаарын хөлгийн зогсоолын засварын ажил хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202006 дугаартай тендерийг 2022.03.04-ны өдөр зарлаж, 2022.04.18-ний өдөр нээхээр байсан ч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хүчингүй болгосон.

2.5.6 "Яамны өр, авлагыг бууруулах арга хэмжээ авна" /БТГ, 4 улирал/



Биелэлт: Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/141 дүгээр тушаалаар 221,0 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хурлаар шүүхийн шийдвэр гарсан болон шүүх хүлээн авах боломжгүй, нотлох баримт хангалтгүй шалтгаанаар буцаасан авлагуудыг хаах, холбогдох бичилт хийх тухай Төрийн нарийн бичгийн даргын тушаал гаргуулахаар ажлын хэсгийн шийдвэр гарсан. Төрийн нарийн бичгийн тушаал гаргахад шаардлагатай нотлох баримтуудыг Үндэсний төв архиваас авч, тушаалын төслийн боловсруулсан. Батлагдах шатанд байна.

3.1.8 “Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангана” /БТГ, 1-4 улирал/

Биелэлт: Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн зээлийн хэлэлцээр Дэлхийн банк болон Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам хооронд 2022 оны 04 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд явагдаж амжилттай дууссан. Төслийг Дэлхийн банкны Захирлуудын зөвлөл 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр баталсан. Төслийн зээлийн хэлэлцээрийг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжих УИХ-д өргөн барьсан. УИХ-ын холбогдох байнгын хорооны хуралдаанаар 2022-12-13-ны өдөр хэлэлцэн дэмжээд байна. Зээлийн хэлэлцээрийн төслийг батлагдахад бэлэн болсон. ЗТХС-ын 2022 оны А/45 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг тус төслийн нэгжийн бүтэц, бүрэлдэхүүний саналыг боловсруулан ДБ-наас санал авахаар хүргүүлсэн.

Гурав. Үнэлэлт, дүгнэлт:

3.1.Төлөвлөлтийн байдал:

3.1.1. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу 2022 оны яамны болон нэгжүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, шалгуур үзүүлэлтийн дагуу төлөвлөсөн. Мөн яам болон харьяа байгууллагыг үнэлэх хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг Сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар батлуулан, зам, тээврийн салбарын хэмжээнд мөрдүүлэн ажиллаж байна.

3.1.2. Яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг буруу тодорхойлсон, хэрэгжүүлэх хугацааг яамны болон нэгжийн төлөвлөгөөтэй зөрүүлсэн зэрэг алдаа гарсан байна.

3.1.3. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний дундаж үнэлгээ зөрүүтэй үнэлэгддэг. Энэ нь бодлогын баримт бичигт туссан арга хэмжээ нь яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тухайн жилийн зорилтод түвшингээр тогтоож, зорилтод түвшинг хэрэгжүүлэх хугацааг хагас, бүтэн жилээр төлөвлөсөн.

3.2. Хэрэгжилтийн байдал:

3.2.1. Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 134 арга хэмжээний хэрэгжилт **85.04** хувь байна. Энэ нь өнгөрсөн жилийн мөн үес 2.66 хувиар үнэлгээ буурсан байна.



3.2.2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төрийн хэмнэлтийн тухай хууль, 2022 оны батлагдсан төсөв, хөрөнгө багассан зэрэг шалтгаанаар зарим арга хэмжээ нь жилийн эцсийн байдлаар зорилтод түвшинд хүрэх боломжгүй нөхцөл үүссэн. Мөн шалтгаанаар үнэлгээнд тооцогдоогүй 5 арга хэмжээ байна.

3.2.3. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтод түвшинг хагас болон бүтэн жилээр журмын дагуу төлөвлөсөн нь хэрэгжилтийн дундаж үнэлгээ өссөн байна. Энэ нь өмнөх улирлаас бүрэн хэрэгжсэн 18 арга хэмжээ, 90 хувийн үнэлгээтэй 11 арга хэмжээгээр нэмэгдүүлж, 30 хувьтай хэрэгжилттэй 21 арга хэмжээг 10 болгон бууруулсан нь жилийн эцсийн үнэлгээ өсөхөд нөлөөлсөн.

Дөрөв. Санал, зөвлөмж:

4.1. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 2022 оны батлагдсан төсөв, хөрөнгө багассан тул хөрөнгийн асуудалтай, хөрөнгө шийдэгдээгүй, тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болсон 5 арга хэмжээг жилийн эцсийн байдлаар үнэлгээнд тооцогдоогүй байна. Иймд эдгээр арга хэмжээг 2023 оны яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газарт;

4.2. Хөрөнгө, санхүүжилт шийдэгдээгүй байгаа арга хэмжээнүүдийн талаар Сангийн яаманд төсөвт тусгуулах санал хүргүүлэхээс гадна гадаадын зээл, тусламж, концессоор хэрэгжүүлэх боломжийг судлан бусад арга замаар хөрөнгө оруулалт шийдэх, эрчимжүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллах, санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлуудад анхаарч ажиллахыг бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрууд болон Бодлого, төлөвлөлтийн газарт;

4.3. Салбарын хуулийн төслүүдийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулах, хөрөнгө санхүү шаардагдахгүй ч удаашралтай байгаа арга хэмжээг эрчимжүүлэх, үнэлгээнд тооцогдоогүй 5 арга хэмжээ, 30-50 хувьтай 15 арга хэмжээг онцгойлон анхаарч 2023 онд бүрэн хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрууд болон Бодлого, төлөвлөлтийн газарт;

4.4. Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журамд өөрчлөлт орсон тул Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг 2023 оны I улиралд шинэчлэн батлуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт;

4.5. Яамны холбогдох тайлан, мэдээллийг хяналт-шинжилгээ, үнэлгээний програмд тодорхой тоо баримт, огноотой, товч тодорхой бөгөөд нэг арга хэмжээг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнахыг анхаарч ажиллахыг нийт албан хаагчдад тус тус зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:

САЙД

С.БЯМБАЦОГТ



ДЭД САЙД

Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

Ц.ОДХҮҮ

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

АВТО ЗАМЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ЗАМ АШИГЛАЛТ,
ЗАСВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.СУГАРМАА

АВТО ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА

Ё.ЖАРГАЛСАЙХАН

ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА

М.ЭНХБОЛД

ХЯНАСАН:
ХШУДАГ-ЫН ДАРГА

А.МОНХБАТ

БОЛОВСРУУЛСАН:
ХШУДАГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Э.СОЛОНГО

**ЗТХЯ-НЫ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛАР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**


/2022 оны жилийн эцсийн байдлаар/

№	Нэгж	Нийт	Үнэлгээ /хувиар/							ХШУ
			100	90	70	50	30	0	ХБ	
1	БТГ	27	13	6	5	1	2	-	-	85.2
2	ТЗУГ	14	7	4	2	-	-	-	1	92.3
3	А3БХ3Г	39	20	10	3	-	4	-	2	87.3
4	ИНБХ3Г	13	2	4	4	1	1	-	1	76.7
5	АТБХ3Г	10	3	2	2	3	-	-	-	77.0
6	Т3ДТБХ3Г	19	3	10	2	-	3	-	1	79.4
7	ХШУДАГ	12	4	8	-	-	-	-	-	93.3
Нийт		134	52	44	18	5	10	-	5	85.04

ЗТХЯ-НЫ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛАР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДУН

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

Нэгдсэн дун 85.04



ЗТХЯ-НЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДУНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:

/Яамны бүтцийн нэгжээр/

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

